



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2007 оны 3 сарын 29 өдөр

Дугаар 124

Улаанбаатар хот

"Нийслэлийн инженерийн зөвлөл" байгуулах тухай

Монгол Улсын "Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай" хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3, 29.1.4, 29.1.5, 29.1.6 дахь заалтуудыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

Нэг. Нийслэл хотын инженерийн нэгдсэн бодлогын хэрэгжилтийг хангуулах "Нийслэлийн инженерийн зөвлөл"-ийг байгуулан 2007 оны 3 дугаар сарын 30-наас ажиллуулсугай.

Хоёр. "Нийслэлийн инженерийн зөвлөл"-ийн дүрмийг нэгдүгээр хавсралтаар, бүрэлдэхүүнийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

Гурав. Нийслэл хотын нутаг дэвсгэрийн инженер геологи, экологи, үерийн хамгаалалт, гамшиг аюулгүй байдал, барилга байгууламж, хийц конструкци, автозам, дэд бүтцийн инженерийн бодлогын хэрэгжилтийг дүрмээр хүлээсэн үүргийн дагуу нэгдсэн удирдлагаар хангаж ажиллахыг "Нийслэлийн инженерийн зөвлөл"- /Г.Мөнхбаяр/-д даалгасугай.

Дөрөв. Энэхүү захирамжийн биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Засаг даргын Тамгын газар /Ц.Болдсайхан/-т үүрэг болгосугай.



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР
ХОТЫН ЗАХИРАГЧ

Ц.БАТБАЯР



Нийслэлийн Засаг даргын 2007 оны
3 дугаар сарын 29-ны өдрийн
12.4 дугаар захирамжийн нэгдүгээр
хавсралт

НИЙСЛЭЛИЙН "ИНЖЕНЕРИЙН ЗӨВЛӨЛ"-ИЙН ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1 Нийслэлийн "Инженерийн зөвлөл"-ийн зорилго нь /цаашид зөвлөл гэх/Нийслэл хотын Нийслэл хотын нутаг дэвсгэрийн инженер геологи, экологи, үерийн хамгаалалт, гамшиг аюулгүй байдал, барилга байгууламж, хийц конструкци, автозам, дэд бүтцийн инженерийн бодлогын хэрэгжилтийг хангуулах, гадаад, дотоодын хөрөнгө оруулалтаар хэрэгжих төслийн баримт бичгийг хэлэлцэн инженерийн нэгдсэн шийдлийн талаар дүгнэлт гаргахад оршино.

1.2. Зөвлөл орон тооны бус бүрэлдэхүүнтэй байх ба үйл ажиллагаа явуулах хэлбэр нь хурал байна.

1.3. Зөвлөл нь ажлаа Нийслэлийн Засаг даргад хагас жил тутам танилцуулна.

Хоёр. Зөвлөлийн үйл ажиллагааны үндсэн чиглэл

2.1. Зөвлөл нь үйл ажиллагаандаа Монгол улсын Барилгын тухай, Хот байгуулалтын тухай, Усан хангамж, ариутгах татуургын тухай, Эрчим хүчний тухай, Автозамын тухай болон бусад хууль тогтоомж, энэхүү дүрмийг мөрдлөг болгоно.

2.2. Нийслэл Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх Ерөнхий төлөвлөгөөний хэрэгжилтийг хангуулах ажлыг зохион байгуулна.

2.3 Нийслэл хотын нутаг дэвсгэрийн инженер геологийн судалгаа, дүгнэлт, газар хөдлөл, үерийн хамгаалалт зэрэг гамшгаас хамгаалах арга хэмжээний талаархи холбогдох норм, нормативын шаардлагыг хангуулах

2.4 Инженерийн хийцтэй барилга байгууламжийн ашиглалт, төлөвлөлтийн талаархи норм, норматив, журмын хэрэгжилтийг хангуулах

2.5 Хөрсийг эвдрэл, бохирдол, элэгдлээс сэргийлэх, хамгаалах арга хэмжээг авч хэрэгжүүлэх

2.6 Ногоон байгууламжийн ашиглалт, арчилгааг сайжруулах, чимэглэх урлаг, ландшафтын шаардлагыг хангуулах

2.7 Хот байгуулалт, газар зохион байгуулалт, дэд бүтцийн хөгжлийн хэтийн болон ойрын зорилтуудад инженерийн хангамжийн шийдлийг тусгуулах

2.8. Салбарын хөгжлийн бодлогын баримт бичиг болон барилга, автозам, инженерийн шугам сүлжээний ашиглалттай холбогдох хууль тогтоомж, норм ба дүрэм, стандарт, журамд өөрчлөлт оруулах санал боловсруулах,

2.9. Хот төлөвлөлтийн болон инженер геологи, газар хөдлөлийн бичил мужлалын баримт бичгүүдэд дүгнэлт хийх .

2.10 Улаанбаатар хотын авто зам, замын байгууламжууд, инженерийн шугам сүлжээ, барилга байгууламжийн паспортжуулалт, өндөр барилгын техник технологийн шийдлийн асуудлыг хэлэлцэж дүгнэлт гаргах

2.11 Нийслэл Улаанбаатар хотын инженерийн бодлогын асуудлыг нэгтгэн зангидах, уялдаа холбоог хангах, шинжлэх ухаан техникийн ололт, дэвшилтэт техник технологи нэвтрүүлэх оновчтой шийдлийг сонгон тодорхойлох

2.12 Улаанбаатар хотын инженерийн бодлогыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд салбарын ашиглалтын байгууллагуудаас олгож буй инженерийн хангамжийн техникийн нөхцөл, шугам сүлжээний ашиглалтын талаархи мэдээллийг хагас жил тутам танилцаж дүгнэлт гаргах

Гурав. Зөвлөлийн эрх

3.1. Орон сууцны хороолол, хотхоны инженерийн хангамжийн шийдэлд орчин үеийн дэвшилтэт техник технологийг нэвтрүүлэх, насжилтыг уртасгах нөхцлийг бүрдүүлэх

3.2. Нийслэлийн хотын нутаг дэвсгэрийн инженер геологи, экологи, газар хөдлөл, өндөржилт, үерийн хамгаалалт, гамшиг аюулгүй байдал, барилга байгууламж, автозам, радио холбоо, дулаан хангамж, цахилгаан хангамж, усан хангамж, ариутгах татуургын чиглэлээр хийгдсэн судалгаа болон тухайн салбарын хэтийн хөгжлийг тодорхойлсон баримт бичгүүдийг авч хэлэлцэн уялдуулж санал өгч, дүгнэлт хийх

3.3. Зөвлөлийн хурлаар хэлэлцэх асуудалтай холбогдох зөвлөх болон мэргэшсэн мэргэжилтнүүдийг урилгаар оролцуулах, хэлэлцэгдэж буй асуудлын хүрээнд мэргэжлийн байгууллагаар харьцуулсан тооцоо, судалгаа, санал, дүгнэлт гаргуулах.

3.4 Зөвлөлийн хурлаас гарсан дүгнэлтийн хэрэгжилтэнд хяналт тавих, шаардах.

3.5 Нийслэлд гарч буй дэд бүтэцтэй холбогдох зөрчил маргаантай асуудлуудаар судалгаа, дүгнэлт гаргуулах, таслан зогсоох эрх зүйн орчинг бүрдүүлэх зорилгоор хууль, дүрэм, норм нормативт өөрчлөлт оруулахыг санаачлах

3.6 Дэд бүтцийн /авто зам, цэвэр, бохир усан хангамж, дулаан хангамж, цахилгаан хангамж, инженерийн бэлтгэл арга хэмжээ, үерийн далан суваг гэх мэт/ салбарын чиглэлийн эрдэм шинжилгээ, судалгааны ажилтай жил бүр танилцан хэрэгжилтийг хангуулах, хамтран ажиллах

3.7 Холбогдох норм нормативыг зөрчсөн инженерийн шийдэл болон эрүүл ахуй, аюулгүйн шаардлага хангахгүй аливаа үйл ажиллагааг зогсоох санал оруулах

Дөрөв. Зөвлөлийн үүрэг

4.1. Аливаа хэлэлцэгдэж буй асуудлыг хот байгуулалт, төлөвлөлтийн өндөр түвшинд, хууль дүрэм, журам, норм нормативын хүрээнд шийдвэрлэх зорилт тавин, шинжлэх ухааны ололт, орчин үеийн техник технологийн шийдлийг тусгах нөхцлийг бүрдүүлэх.

4.2. Зөвлөлийн хурлын дүгнэлтийг үндэслэн техникийн шийдлийн асуудлуудыг холбогдох мэргэжлийн байгууллагуудад тавьж шийдвэрлүүлэх.

4.3. Төрөөс явуулж буй нийгэм, эдийн засаг, хот байгуулалтын бодлогын хүрээнд нийслэлд хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэлтэй танилцах, санал өгөх, уялдуулах, шаардлагатай тохиолдолд санал оруулах

4.4. Улс, нийслэлийн болон олон улсын байгууллагын хөрөнгө оруулалтаар хийгдэж буй ажлын явц, үр дүнтэй улирал тутам танилцах

4.5. Зөвлөл нь холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн дүгнэлт гаргах.

4.6. Зөвлөлийн гишүүдийг зөвлөлийн үйл ажиллагаанд идэвхтэй ажил хэрэгч оролцуулах нөхцлийг бүрдүүлэх

Тав. Зөвлөлийн ажиллах журам, зохион байгуулалт

5.1. Зөвлөлийн гишүүд нь мэргэжлийн, мэрэгшсэн мэргэжилтнүүд байх бөгөөд зөвлөлийн бүрэлдэхүүнийг Нийслэлийн Засаг даргын захирамжаар томилно.

5.2. Зөвлөл нь дарга, нарийн бичгийн даргатай байна.

5.3. Зөвлөл нь сард нэг удаа хуралдах ба шаардлагатай тохиолдолд ээлжит бус хурлыг зарлан хуралдуулж болно. Хурлаар хэлэлцэх асуудлын төлөвлөгөө боловсруулан батлуулж, гишүүдэд урьдчилан тараана.

5.4. Зөвлөл нь гишүүдийнхээ 60-аас дээш хувийн ирцтэйгээр асуудлыг хэлэлцэн олонхийн саналаар зөвлөмж, дүгнэлт гаргана.

5.5. Зөвлөл нь шаардлагатай тохиолдолд зарим асуудлыг өргөтгөсөн бүрэлдэхүүнтэй хэлэлцэнэ.

5.6. Зөвлөл нь хэлэлцсэн асуудлаар протокол үйлдэнэ.



Нийслэлийн Засаг даргын 2007 оны
3 дугаар сарын 29-ны өдрийн
124-р хороо... захирамжийн хоёрдугаар
хавсралт

**"НИЙСЛЭЛИЙН ИНЖЕНЕРИЙН ЗӨВЛӨЛ"-ИЙН
БҮРЭЛДЭХҮҮН**

- Зөвлөлийн дарга: -Улаанбаатар хотын Ерөнхий менежер
- Орлогч дарга: -Улаанбаатар хотын ерөнхий инженер бөгөөд
Захирагчийн ажлын албаны Инженерийн
байгууламжийн хэлтсийн дарга
- Гишүүд:
- Хотын хөгжлийн бодлогын хэлтсийн дарга
 - Барилга, хот байгуулалт, төлөвлөлтийн газрын
ерөнхий инженер
 - Барилга, хот байгуулалтын яамны Хот
байгуулалтын газрын дарга /зөвшилцснөөр/
 - Түлш эрчим хүчний яамны Түлш, эрчим хүчний
бодлого, стратеги төлөвлөлтийн газрын газрын
дарга /зөвшилцснөөр/
 - Байгаль орчны яамны Хүрээлэн буй орчин,
байгалийн нөөцийн газрын дарга /зөвшилцснөөр/
 - Зам, тээвэр, аялал жуулчлалын яамны Автозамын
газрын дарга /зөвшилцснөөр/
 - Барилга, хот байгуулалт, төлөвлөлтийн газрын
хэлтсийн дарга
 - Ус сувгийн удирдах газрын ерөнхий инженер
 - Нийслэлийн Автозамын газрын орлогч дарга
 - “Улаанбаатар дулааны сүлжээ” ХК-ний ерөнхий
инженер
 - “Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ” ХК-ний
ерөнхий инженер
 - Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын
байгаль орчин, дэд бүтцийн хяналтын хэлтсийн
дарга
 - Орон сууц, нийтийн аж ахуйн удирдах газрын
ерөнхий инженер

- Нийслэлийн Онцгой байдлын газрын дэд дарга
- Усны барилга байгууламж НӨҮГ-ын ерөнхий инженер
- Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн Барилга инженерийн сургуулийн захирал
- Хотын хөгжлийн бодлогын хэлтсийн салбарын асуудал хариуцсан мэргэжилтэн
- Барилга хот байгуулалт, төлөвлөлтийн газрын салбарын асуудал хариуцсан мэргэжилтэн
- Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Инженерийн байгууламжийн хэлтсийн салбарын асуудал хариуцсан мэргэжилтэн
- Зөвлөх инженерүүд /урилгаар/
- Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хотын хөгжлийн бодлогын хэлтсийн мэргэжилтэн

Нарийн бичгийн
дарга: